



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/130

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019 онд Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан “Сайхан-Овоо суманд бохир сорох автомашин нийлүүлэх” ажлын эрхийг Сайхан-Овоо сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж гэрээ байгуулан, ажлыг чанартай гүйцэтгүүлж ажиллахыг Сайхан-овоо сумын Засаг дарга (Б.Түвшинбаатар)-д үүрэг болгосугай.

Гурав. Эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190370